

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

Санамж: Нэгдүгээр хэсэг нь 56 сонгох даалгавар нийт 76 оноотой. Даалгавар бүр 5 сонгох хариулттай бөгөөд зөвхөн нэг зөв хариултыг сонгож хариултын хуудсанд будаж тэмдэглээрэй. Хариултын хуудасны заавартай сайтар танилцаарай. Амжилт хүсье.

1. Адилтгах замаар зөв хариултыг сонгоно уу. (1 оноо)

a. **5–1 сая жилийн өмнө - Австролопитек**

b. **800.000 жилийн өмнө – Монголд?**

A. Хомо сапиенс сапиенс

B. Хомо эректус

C. Хомо хабилис

D. Неандерталь

E. Хомо сапиенс

2. Эртний хүмүүсийн амьдралд гарсан дэвшил, ололтыг чулуун зэвсгийн үечлэлээр нь төгсгөлөөс эхлэл рүү зөв эрэмбэлсэн хариултыг олно уу. (2 оноо)

1. Нум сум

2. Хэл яриа

3. Гал

A. 3, 2, 1

B. 1, 2, 3

C. 2, 1, 3

D. 3, 1, 2

E. 2, 3, 1

3. Неолитын үеийн Монгол нутагт оршин суугчдын дунд гар урлал шинэ шатанд хөгжсөнийг юугаар нотолдог вэ? (1 оноо)

A. Хадны зураг

B. Хүрэл зэвсэг

C. Шавар ваар

D. Ширмэл ширдэг

E. Төмөрлөг зэвсэг

4. НТӨ XIV-VIII зуунд холбогдох дэлхийн соёлын өвд бүртгэгдсэн нүүдэлчдийн дурсгал аль нь вэ? (1 оноо)

A. Буган хөшөө

B. Дөрвөлжин булш

C. Хиргисүүр

D. Түүвэр олдвор

E. Чандманы соёл

5. НТӨ 1792 онд Месопотамийг эзэлж, Вавилон улсыг үндэслэн байгуулсан хаан хэн бэ? (1 оноо)

A. Навуходоносор

B. I Саргон

C. Ашурбанипал

D. Хаммурапи

E. II Саргон

6. Он тооллын шугамыг анхааралтай ажиглан, доорх асуултад тохирох хариултыг сонгоно уу. (2 оноо)



a. Дунд Египет хэдэн жил оршин тогтносон бэ?

b. Дунд Египет хэдээс хэддүгээр зуунд оршин тогтнож байсан бэ?

A. a. 1569 жил, b. НТӨ XXVIII-XXI зуун

B. a. 4960 жил, b. НТӨ XXIX-IV зуун

C. a. 4925 жил, b. НТӨ XVI-XI зуун

D. a. 810 жил, b. НТӨ XXI-IV зуун

E. a. 480 жил, b. НТӨ XXI-XVI зуун



7. Хүснэгтийг ажиглан эртний Энэтхэг улсад холбогдох зөв хариултыг сонгоно уу. (2 оноо)

1. Газар нутаг	2. Түүхэн зүтгэлтэн	3. Улс
a. Нил мөрөн	a. Канишка	a. Аккадын хаант улс
b. Ганга мөрөн	b. Нармер	b. Кушан улс
c. Евфрат мөрөн	c. Сенусерт	c. Ся улс

A. 1b, 2a, 3a B. 1b, 2c, 3a C. 1a, 2a, 3c D. 1b, 2a, 3c E. 1b, 2a, 3b

8. “Уди хаан, энх ургийн гэрээ, түүхэн тэмдэглэл” хэмээх ойлголтууд нь эртний Хятадын ямар улсад холбогдох вэ? (1 оноо)

A. Шан B. Хан C. Жоу D. Ся E. Цинь

9. Цэгийн оронд тохирох хариултыг сонгоно уу. (1 оноо)

Эртний Грекийн иргэншил нь Эгейн тэнгис дэх хойгийн баруун, зүүн өмнөд талд олон тооны аралд (1400 орчим) бүрэлдэн тогтжээ.

A. Солонгосын B. Аппениний C. Скандинавын D. Балканы E. Энэтхэг, Хятадын

10. Эртний Ромын түүхэнд холбогдох үйл явдлуудыг он цагийн зөв дараалалд оруулсныг сонгоно уу. (2 оноо)

1. Пунийн дайн болов.

2. Ромын анхны бичмэл “12 самбарын хууль”-ийг батлав.

3. Баруун Ромын эзэнт улс мөхөв.

A. 2, 1, 3 B. 3, 2, 1 C. 1, 2, 3 D. 2, 3, 1 E. 3, 1, 2

11. Хүннү гүрний өмнөд хил хязгаар хаана хүрч байсан бэ? (1 оноо)

A. Байгал нуур B. Хянганы нуруу C. Цагаан хэрэм D. Алтайн нуруу E. Дорнод Туркестан

12. Он тооллын шугамыг ашиглан зөв хариултыг сонгоно уу. (2 оноо)

2026 онд “Үндэсний их баяр наадам”-аар Монголын тулгар төр байгуулагдсаны хэдэн жилийн ойг тэмдэглэх вэ?




A. 2119 жил B. 1817 жил C. 302 жил D. 2235 жил E. 819 жил

13. Киргизүүдийг шахан гаргаснаар Монгол нутагт түрэг угсаатны ноёрхлыг халж улмаар 842-923 он хүртэлх үеийг “Татаруудын үе” хэмээн нэрлэдэг. Энэхүү түүхэн цаг хугацаа нь хэддүгээр мянганд хамаарах вэ? (1 оноо)

A. I мянганы I хагас B. II мянганы I хагас C. I мянганы II хагас
D. II мянганы II хагас E. III мянганы I хагас



14. Монгол нутагт байгуулагдсан эртний төрт улсын он тооллын шугамыг анхааралтай ажиглан, доорх асуултад тохирох хариултыг сонгоно уу. (2 оноо)



а. Ямар угсааны улс бэ?

б. Хэн байгуулсан бэ?

А. а. Монгол, б. Амбагян

В. а. Монгол, б. Таньшихуай

С. а. Түрэг, б. Буман

Д. а. Түрэг, б. Пэйло

Е. а. Монгол, б. Чарагуй

15. Ноёны уулын язгууртны булшнаас ширмэл ширдэг олджээ. Энэхүү олдвор нь эртний ямар улсын түүхэнд холбогдох вэ? (1 оноо)

А. Жужан

В. Сяньби

С. Хүннү

Д. Түрэг

Е. Уйгур

16. Монголын эртний улсуудын аж ахуй, соёлын ололтуудаас Хятан улсын үед хамаарах хариултыг зөв сонгоно уу? (1 оноо)

1. Их, бага бичиг

2. Хоёр ёс

3. Төмөр дөрөө

4. Ахын дуу

5. Тариалангийн хууль

А. 2, 4

В. 1, 2

С. 3, 5

Д. 2, 3

Е. 1, 5

17. Франк улсын хаадаас 50 гаруй удаагийн аян дайн хийж, Баруун Ромын эзэнт улстай эн тэнцэхүйц хүчирхэг болгосон хаан хэн бэ? (1 оноо)

А. Немец Людвиг

В. Хлодвиг

С. Карл Мартелл

Д. Намхан Пипин

Е. Их Карл

18. Доорх сурвалжийн мэдээ нь дундад зууны өрнө дахины ямар улсын тухай өгүүлж байна вэ? (2 оноо)

“Дэлхийн нэг ч сүмд ийм баялгийг олж харахгүй биз ээ. Сүмийн дотор баганат танхим, тоо томшгүй олон алт, мөнгөөр хийсэн зул асааж, ордны дэргэд зугаа цэнгэлийн газар – морин тойруулга бий”/ 1117 оны 12 сард Константинополь хотод айлчилсан Туделийн Вениаминий тэмдэглэлээс/

А. Вандаул улс


В. Орос улс

С. Франк улс

Д. Византын эзэнт улс

Е. Зүүн Гот улс

19. Бүдүүвчийг ажиглан баруун славянд хамаарах өнөөгийн улсыг сонгоно уу. (1 оноо)



А. Польш

В. Словак

С. Орос

Д. Беларусь

Е. Чех



20. Дундад зууны үеийн Майя, Ацтек, Инк зэрэг улсуудтай холбогдох **a, b** жагсаалтыг ямар шалгуураар гаргасан бэ? (2 оноо)

a. Теночтитлан, Куско, Чичен - Ица

b. Нарны хуанли, одон орон, бичиг үсэг, сургууль

A. a. Нийслэл хот, b. аж ахуй

B. a. Нийслэл хот, b. соёлын ололт

C. a. Газар нутаг, b. ач холбогдол

D. a. Байгаль газар зүй, b. соёлын хөгжил

E. a. Эх сурвалж, b. соёлын ололт

21. Мэдээллийг уншиж, тохирох түлхүүр үгийг сонгоно уу. (2 оноо)

845 онд Ву Зон хааны зарлигаар (1)шашны 4600 сүм хийдийг буулгаж, 250.000 ламыг хүчээр хар болгосон байна. Х зууны эхний хагаст Хятадад (2) гаргаж сурчээ. Европт үүнээс 300 жилийн дараа хэрэглэж эхэлсэн юм. Хятад орон дахин задарч жанжин Жао Куанжин 960 онд Хятадын нэгдмэл байдлыг сэргээн(3).....ыг байгуулжээ.

1	2	3
a. Шинто	a. Шаазан урлал	a. Сүн улс
b. Загалмайн	b. Дарь	b. Тан улс
c. Бурхны	c. Торго	c. Сүй улс

A. 1c, 2b, 3a

B. 1b, 2a, 3c

C. 1b, 2c, 3a

D. 1c, 2a, 3b

E. 1a, 2b, 3c

22. Энэтхэг улсын кастын тогтолцоог нийгэмд гүйцэтгэж буй үүргээр нь зөв тохируулна уу? (1 оноо)

1. Брахман

a. Санваартны үүргийг гүйцэтгэх

2. Шудра

b. Дээд давхаргынханд үйлчлэх

3. Вашья

c. Удирдах, дайтах

4. Кшатра

d. Худалдаа, гар урлал, газар тариалан эрхлэх

A. 1a, 2b, 3d, 4c

B. 1a, 2c, 3d, 4b

C. 1d, 2c, 3a, 4b

D. 1a, 2b, 3c, 4d

E. 1d, 2b, 3a, 4c

23. Адилтгах замаар зөв хариултыг сонгоно уу. (1 оноо)

a. Бурхны зам – Шинто

b. Мандах нарны орон - ?

A. Катакана

B. Хирагана

C. Харакири

D. Ниппон

E. Самурай

24. Ниругун овог хэнээс үүсэлтэй вэ?

(1 оноо)

A. Бөртэ чоно

B. Алунгоо эхийн 3 хөвгүүн

C. Хабул


D. Добу мэргэн

E. Бодончар мунхаг



25. XII зууны газрын зурагт Хэрэйд улсын газар нутгийг ямар тоогоор тэмдэглэсэн байна вэ?

(2 очко)



A. 2

B.1

C. 4

D. 3

E. 5

26. Цэргийн жанждаас **Хубилай, Зэлмэ, Зэв, Сүбээдэй** нарыг Чингис хаан хэрхэн онцгойлон үнэлж нэрлэсэн бэ? (1 оноо)

A. Дөрвөн хүлэг B. Дөрвөн нохос C. Дархан D. Төрийн бэхи E. Түмтийн ноёд

27. Чингис хааны Монголын түүхэнд гүйцэтгэсэн үүргийг зөв ялгасан хэсгийг сонгоно уу.

(1 OHOO)

1. Их Монгол улсыг байгуулав.
2. Евразийг дамнасан газар нутагт нэгдсэн дэг журам тогтоов.
3. Өрнө, дорнын улсуудын хооронд худалдаа, соёлын харилцаа хөгжив.
4. Хархорум хотыг байгуулах зарлиг буулгав.

A. 2, 3

B. 1, 2

C. 3, 4

D. 1, 4

E. 2, 4

28. Гүюг хаан 1247 онд Сүн улсыг эзлэх дайныг эхлүүлэв. Уг үйл явдал нь Чингисийн тооллын хэдэн онд болсон бэ? (1 оноо)

А. Чингисийн 85 он

В. Чингисийн 86 он

С. Чингисийн 41 он

D. Чингисийн 58 он

Е. Чингисийн 84 он

29. Өнөөгийн Иран, Ирак, Азербайжан, Армян, Гүрж, Турк, Афганистаны баруун хэсэг, Сирийн хойд хэсгийн нутаг дэвсгэрийг нэгтгэн захирч байсан Монголын эзэнт гүрний бүрэлдэхүүн улсыг сонгоно уу. (1 оноо)

А. Их Юань улс

В. Цагадайн үлс

С. Ил хаант үлс

D. Алтан Ордны улс

Е. Их Монгол улс



30. Хүснэгтийг ажиглан Алтан Ордны улсад холбогдох зөв хариултыг сонгоно уу. (2 оноо)

1. Түүхэн зүтгэлтэн	2. Он цаг	3. Соёлын ололт
a. Хүлэгү	a. 1271 он	a. Судрын чуулган
b. Бат	b. 1242 он	b. Кебек хааны зоос
c. Хубилай	c. 1221 он	c. Дөрвөлжин бичиг
d. Цагадай	d. 1256 он	d. Абдулла ноёны гэрэгэ

A. 1c, 2b, 3c B. 1b, 2d, 3a C. 1b, 2b, 3d D. 1a, 2a, 3d E. 1d, 2c, 3b

31. 1368 онд Монголын улс төрийн төв эх нутагтаа төвлөрснөөр Хятадад ямар улс байгуулагдсан бэ? (1 оноо)

A. Чусон B. Төвөд C. Киргиз D. Орос E. Мин

32. Дорнод Монголын баруун гурван түмнийг зөв сонгоно уу. (1 оноо)

A. Цахар, Түмэд, Урианхай B. Халх, Урианхай, Цахар C. Ордос, Түмэд, Юншээбүү
D. Дөрвөд, Урианхай, Торгууд E. Ордос, Түмэд, Урианхай

33. XVII зууны Монголын бие даасан улсуудаас **1691 он, Эрдэнэ зуу, Гэрсэнз** зэрэг ойлголтууд нь аль улсад холбогдох вэ? (1 оноо)

A. Халх Монгол B. Өвөр Монгол C. Зүүнгар улс
D. Хошууд улс E. Хотгойд улс

34. Доорх өгөгдлийг зөв харгалзуулна уу. (2 оноо)

1. Өвөр Монгол a. Баруун гар Засагт хан, Зүүн гар нь Түшээт хан, Сэцэн хан аймаг
2. Халх Монгол b. Цорос, Хошууд, Дөрвөд, Торгууд
3. Ойрад Монгол c. Хорчин, Жарууд, Баарин, Түмэд, Харчин

A. 1c, 2b, 3a B. 1b, 2a, 3c C. 1b, 2c, 3a D. 1c, 2a, 3b E. 1a, 2b, 3c

35. XVII зууны үед монгол бичгийг ярианы хэлтэй ойртуулах, Төвөд ба санскрит үгийг хялбар бичих зорилгоор хэн, ямар үсгийг зохиосон бэ? (1 оноо)

A. Намхайжамц, тод B. Аюуш гүүш, али гали C. Занабазар, соёмбо
D. Пагва лам, дөрвөлжин бичиг E. Агваандорж, вагиндра

36. XIV-XVII зууны үеийн монголын уран зохиолд дотоодын дайн дажныг эсэргүүцсэн, нэгдэл нягтрал, энх амгалан амьдрал, сайн сайхныг мөрөөдөн уриалсан утга санаа голлосон зохиолууд гарч байв. Эдгээр бүтээлүүдээс аль нь хамаарах вэ? (1 оноо)

1. Жангар 2. Монголын нууц товчоо 3. Шар тууж
4. Мандухай хатны домог 5. Эрдэнийн товч

A. 3, 4 B. 1, 2 C. 4, 5 D. 1, 4 E. 1, 5

37. Лигдэн хаан нас барснаар 1636 онд Өвөр Монголын ноёд чуулган хийж хаана, хэнд дагаар орсон бэ? (1 оноо)

A. Ар элстэйд, Занабазар B. Долоон нуурт, Энх-Амгалан C. Цахард, Лигдэн
D. Бээжинд, Нурхач E. Мүгдэнд, Абахай



38. Халимаг, Буриадын түүхэнд холбогдох үйл явдлуудыг он цагийн хувьд зөв дараалалд оруулсныг сонгоно уу. (1 оноо)

1. Манж–Оросын хооронд Нэрчүгийн гэрээ байгуулав.
2. Халимаг–Орос цэргийн холбооны гэрээ байгуулав.
3. Халимагийн сүүлчийн их нүүдэл болов.

A. 2, 3, 1 B. 3, 2, 1 C. 2, 1, 3 D. 1, 3, 2 E. 1, 2, 3

39. Дайчин төрөөр нэгтгэх бодлогыг ямар хаан хэрэгжүүлж байсан бэ? (1 оноо)

- A. Лигдэн хутагт хаан B. Галдан бошогт хаан C. Түмэн засагт хаан
D. Батмөнх даян хаан E. Түмэдийн Алтан хан

40. Монголчууд харийн эрхшээлд ороход нөлөөлсөн гадаад шалтгаан аль нь вэ? (1 оноо)

- A. Зүүнгар улс болон Халх Монгол хоорондоо эв түнжингүй байсан.
B. Монголын их хааны сүр хүч буурч, төвлөрсөн засаглал суларсан.
C. Халхын баруун, зүүн гар хоорондоо дайсагнасан байдалтай байсан.
D. Монголчууд Мин улстай худалдаа арилжаа хийж байсан.
E. Манж улс хагалан бутаргах, эзлэн түрэмгийлэх бодлого явуулсан.

41. 1858, 1905–1907 онуудад Ордост 300-800 орчим хүнийг хамарсан эсэргүүцэл гарчээ. Энэхүү бослого нь тэмцлийн ямар хэлбэрт хамаарах вэ? (1 оноо)

- A. Дугуйлангийн хөдөлгөөн B. Алба хаях C. Заргын бичиг
D. Зэвсэгт бослого E. Бөөнөөрөө оргон нүүх

42. Хүснэгтийг ажиглан Улиастайд гарсан бослогод холбогдох зөв хариултыг сонгоно уу.

(2 оноо)

1. Түүхэн зүтгэлтэн	2. Он цаг	3. Цэргийн тоо
a. Ард Аюуш	a. 1900 он	a. 800
b. Чингүнжав	b. 1880 он	b. 247
c. Энхтайван	c. 1755 он	c. 2000

A. 1a, 2b, 3b B. 1a, 2d, 3a C. 1c, 2a, 3b D. 1c, 2a, 3c E. 1c, 2c, 3b

43. Монголчууд жил бүр “Тусгаар тогтнолоо сэргээн мандуулсан өдөр”-ийг хэзээ тэмдэглэдэг вэ? (1 оноо)

- A. 11-р сарын 26 B. 3-р сарын 18 C. 12-р сарын 29
D. 10-р сарын 27 E. 1-р сарын 13

44. Богд хаант Монгол улсын үеийн **1914, дөрвөн анги, сургагч** зэрэг ойлголтууд нь ямар сургуулийг илэрхийлж байна вэ? (1 оноо)

- A. Иргэний сургууль B. Цэргийн сургууль C. Шашны сургууль
D. Орос хэл бичгийн сургууль E. Албаны сургууль



45. 1921 онд хувьсгалчид хоорондоо 400-аад нууц түлхүүр үгээр харилцаж байсан бол доорх сурвалжид дурдагдаж буй Георгий гэж хэн бэ? (1 оноо)

“Малын үнэ муу. Хээр морь эмгэгтэй Бутковоос янчаан авах төлөвтэй. Георгийгээр хүргүүлнэ. Мөнгөний явдалд яар. Мөнгөний хариу даруй өг Иван”. Үндэсний Төв Архивын баримтаас

А. Д.Догсом В. Д.Бодоо С. Д.Чагдаржав Д. С.Данзан Е. Х.Чойбалсан

46. Ардын засгийн газрын үеийн **боловсролын** арга хэмжээнд хамаарах онцлох үйл явдлуудыг сонгоно уу. (2 оноо)

1. Тангаргийн гэрээг мөрдүүлэв.
2. Бага, дунд сургуулийн танхимын дүрэм батлав.
3. Улсын түр цагийн хурал байгуулав.
4. Үндэсний мөнгөн тэмдэгттэй болох алхам хийгдэв.
5. Судар бичгийн хүрээлэнг байгуулав.

А. 2, 3 В. 2, 4 С. 1, 5 Д. 2, 5 Е. 4, 5

47. Анхдугаар Үндсэн хуульд зааснаар “Улсын их хурал”-ын чөлөөт цагт ямар байгууллага төрийн эрхтэй байсан бэ? (1 оноо)

А. Улсын бага хурал В. Засгийн газар С. Ерөнхий сайд
Д. УИХ-ын тэргүүлэгчид Е. Ардын их хурал

48. Цэгийн оронд тохирох хариултыг сонгоно уу. (1 оноо)

Шинэ эргэлтийн бодлогыг хэрэгжүүлснээр 1935 онд Монгол кино үйлдвэр байгуулагдаж, дараа жил нь анхны уран сайхны кино дэлгэцнээ гарав.

А. Зэрэг нэмэхийн өмнө В. Ардын элч С. Нийслэл хүү Д. Цогт тайж Е. Монгол хүү

49. Өгөгдлийг зөв тохируулна уу. (2 оноо)

- | | |
|-----------------------------|---|
| 1. 1932 оны 6-р сарын 29-30 | а. Аж үйлдвэрийн комбинат байгуулав. |
| 2. 1934 оны 3-р сарын 26 | б. Радио өргөн нэвтрүүлэг явуулж эхлэв. |
| 3. 1934 оны 9-р сарын 1 | с. Шинэ эргэлтийн бодлогыг хэрэгжүүлэв. |

А. 1a, 2c, 3b В. 1c, 2b, 3a С. 1c, 2a, 3b Д. 1b, 2c, 3a Е. 1a, 2b, 3c

50. Тэгшитгэлийг ашиглаж зөв хариултыг сонгоно уу. (1 оноо)

(Олноо өргөгдсөний 10 он+Ардын хувьсгалын 23 жилийн ой):2+13=?

А. 1939 онд Халх голын дайн болов. В. 1959 онд Соёлын довтолгоо өрнөв.
С. 1945 онд Чөлөөлөх дайн болов. Д. 1976 онд Атрын II аян өрнөв.
Е. 1961 онд Монгол улс НҮБ-д элсэв.

51. МАХН-ын Төв Хорооны тогтоолд “Хүн бүр бага балчраасаа эхлэн туйлын аж ахуйч, арвич хямгач, социалист өмчийн эс ширхэг бүрийг алхам тутамдаа нүдлэн хамгаалагч, хөдөлмөрийг бишрэн шүтэгч байх ёстой” хэмээх сурвалжийн мэдээ нь түүхэн ямар үйл явдлыг илэрхийлж байна вэ? (1 оноо)


А. Сэхээтний төөрөгдөл В. Намын эсрэг бүлэглэл С. Атрын аян
Д. Соёлын довтолгоо Е. Нэгдэлжих хөдөлгөөн



52. Ямар түүхэн үйл явдлаар БНМАУ-д нэг намын ноёрхол эцэс болсон бэ? (2 оноо)

- A. 1990 оны 3 сарын 22-24-нд хуралдсан АИХ-ын чуулган, МАХН бол “төр нийгмийг удирдан чиглүүлэгч цорын ганц хүчин мөн” гэсэн үндсэн хуулийг заалтыг хүчингүй болгосноор
- B. 1990 оны 3 сарын 12-14-нд болсон МАХН-ын бүгд хурлаар улс төрийн товчоо, нарийн бичгийн дарга нарыг бүрэн бүрэлдэхүүнээр огцруулснаар
- C. 1990 оны 3 сарын 9-ний оройн нам төрийн тэргүүн Ж.Батмөнх ард түмэндээ хандан радио телевизээр орон даяар мэдээлэл хийснээр
- D. 1990 оны 3 сарын 7-ны өдрийн 14 цагт МоАХ-ны 10 гишүүн Сүхбаатарын талбайд улс төрийн тэмцлийн хурц хэлбэр болох өлсгөлөн зарлан тэмцсэнээр
- E. 1990 оны 2 сарын 18-нд Монголын ардчилсан намыг эмхлэн байгуулснаар

53. Энэхүү диаграммд хэдэн оны ямар түүхэн үйл явдалтай холбоотой мэдээлэл агуулагдаж байна вэ? (2 оноо)



- A. 1990 оны 7-р сарын 22-29-нд явагдсан олон намын ардчилсан сонгууль
- B. 2000 оны 7-р сарын 3-нд явагдсан УИХ-ын ээлжит сонгууль
- C. 1992 оны 6-р сард бүх нийтийн чөлөөт ардчилсан сонгуулийн дүн мэдээ
- D. 1996 оны 6-р сарын 30-нд явагдсан УИХ-ын сонгууль
- E. 1997 оны ерөнхийлөгчийн ээлжит сонгуулийн дүн мэдээ

54. 1990 оны хувьсгалаар оюун санааны хүрээнд гарсан ололтод холбогдох үйл явдлуудыг он цагийн хувьд зөв дараалалд оруулсныг сонгоно уу. (2 оноо)

- 1. Монголын нууц товчоо зохиогдсоны 750 жилийн ой болов.
- 2. Монгол улсын түүх 5 боть хэвлэгдэв.
- 3. Мэгжид Жанрайсиг шүтээнийг дахин сэргээн Гандантэгчинлэн хийдэд залав.

A. 2, 3, 1 B. 3, 2, 1 C. 1, 3, 2 D. 1, 2, 3 E. 2, 1, 3



55. Ардчилсан хувьсгалын үр дүнд үндэсний үзэл, ухамсар сэргэснийг зөв илэрхийлсэн нь аль вэ? (2 оноо)

- А. 1993 онд Бурхан багшийн чандрыг Монголд залсан.
- В. Спортын салбарт тив, дэлхийн аваргууд олноор төрсөн.
- С. Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль баталсан.
- Д. Чингис, Өгэдэй, Хубилай хаадын хөшөөг төрийн ордны өмнө залсан.
- Е. Электрон технологи бүтээж, цахим сүлжээ чөлөөтэй ашиглах болсон.

56. Он тооллын шугамыг ажиглан Монгол улсын гадаад харилцааны онцлог үйл явдлын түүхэн зүтгэлтэн, он цагийг зөв сонгоно уу. (2 оноо)



- А. 2006, Ши Жиньпин
- В. 2014, В.Путин
- С. 1991, В.Путин
- Д. 1991, Тошику Кайфу
- Е. 2006, Сергей Лавров



ХОЁРДУГААР ХЭСЭГ

Санамж: Хоёрдугаар хэсэг нь 4 даалгавартай тус бүр 6 оноотой. Нийт 24 оноо
Хариултын хуудасны заавартай сайтар танилцаарай.

2.1 Дундад зууны Арабын түүхэнд холбогдох ойлголтуудыг тохируулахдаа 1-7 хүртэлх өгөгдлөөс сонгож зөв харгалзуулна уу. **/1 өгөгдөл илүүг анхаарна уу/** (6 оноо)

- | | |
|----------------------|--|
| a. Хот суурин | 1. Абу Бекр, Осман халиф |
| b. Аж ахуй | 2. Бичиг үсэг, анагаах ухаан |
| c. Шашин шүтлэг | 3. Медин, Мекка |
| d. Мэдлэг, боловсрол | 4. Мусульман, Коран судар |
| e. Газар нутаг | 5. Усан үзэм, арвай тариалах |
| f. Түүхэн зүтгэлтэн | 6. Альгамбрын ордон, Кордова хотын сүм |
| | 7. Арабын хойг, хойд Африк |

2.2 Чингис хаантай холбогдох түүхэн үйл явдлуудыг эхлэлээс төгсгөл рүү он цагаар нь зөв эрэмбэлнэ үү. (6 оноо)

- | | |
|--|-------|
| a. Жамуха Далан Балжудын тулаанд ялалт байгуулав | |
| b. Хубилай хааны зарлигаар ордны зураач Хорихосун Чингис хааны хөргийг зурав | |
| c. Онон мөрний эхэнд их хуралдайгаар Чингис хааныг их сууринд залав | |
| d. Хэрэйдийн Тоорил хантай хамтран татаруудыг бут цохив | |
| e. Наху гүнд Таян ханы цэрэгтэй тулалдаж, Найман улсыг мөхөөв | |
| f. Хэрэйдийн Тоорил хантай эцэг хөвгүүний харилцаа тогтоов | |

2.3 БНМАУ-ын нийгэм, эдийн засагт гарсан өөрчлөлтийг холбогдох ойлголттой нь зөв харгалзуулна уу. (6 оноо)

- | | |
|---------------------------|-------------------------------------|
| a. Аж үйлдвэр, дэд бүтэц | 1. Д.Дамба, Д.Төмөр–Очир, Ц.Лоохууз |
| b. Шинэ эргэлтийн бодлого | 2. Тариаланч, механикжуулагч |
| c. Сэхээтний төөрөгдөл | 3. П.Гэндэн, А.Амар, Х.Чойбалсан |
| d. Нэгдэлжих хөдөлгөөн | 4. Адуучин, хоньчин, саальчин |
| e. Атрын аян | 5. Бичиг үсэг, ариун цэвэр |
| f. Соёлын довтолгоо | 6. Цахилгаан станц, Эрдэнэт үйлдвэр |

2.4 БНМАУ-ын боловсрол, шинжлэх ухаан, соёлын хөгжилд холбогдох үйл явдлуудыг түүхэн зүтгэлтнүүдтэй нь харгалзуулна уу. (6 оноо)

- | | |
|--|----------------|
| a. Монгол хүн сансарт нисэв | 1. С.Буяннэмэх |
| b. Олимпоос анхны мөнгө медалийг хүртэв | 2. Д.Чоймбол |
| c. Сүхбаатарын хөшөөг урлав | 3. Д.Дашдаваа |
| d. Малын вакцин бүтээв | 4. Ж.Гүррагчаа |
| e. Харанхуй засаг жүжгийн зохиолыг бичив | 5. Б.Ширэндэв |
| f. Шинжлэх ухааны академи байгуулав | 6. Ж.Мөнхбат |

